

**УВС АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2022-2024)**

2022 он

**УВС АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**
/Соёл Урлагийн Газрын хөгжлийн дунд хугацааны баримт бичиг/

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Стратеги төлөвлөгөө нь дараах бүтэц, агуулгын хүрээнд боловсруулагдсан байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал
9. Хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшинг баримтлан Соёл, урлагийн газрын ерөнхий чиг үүргийн хүрээнд 7 зорилт, ... арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хөрөнгө, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, үйл ажиллагааны үр дүнг үр нөлөө бүхий байдлаар төлөвлөж, дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангахаар Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулна” гэж заасныг үндэслэн Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг баримтлан Увс аймгийн Соёл, урлагийн газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатыг тодорхойлохдоо чиг үүргийн шинжилгээ хийж, Монгол Улсын Үндсэн хууль болон Соёлын салбарт шууд хамаарах 13 хууль болон аймаг орон нутгийн үйл ажиллагаатай холбогдох нийтлэг мөрддөг 18 хууль, Соёлын яамны Стратеги төлөвлөгөөг удиртгал болгон дараах дөрвөн алхмын хүрээнд “Мандатын шинжилгээ”-г хийлээ.

Үүнд:

1. Хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зэрэг ажлууд орсон.

Эдгээр хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зүйл заалтуудыг нэгтгэн авч үзвэл ерөнхий 7, үндсэн 11, дэд 35 чиг үүрэг тодорхойлогдож байна.

Мандатын шинжилгээ

Салбарын ажиллагаанд байгаа хуулийн тоо	үйл мөрдөгдөж 31	
	Тухайн салбарын хуулийн тоо: 13	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Үндсэн хууль 2. Соёлын тухай 3. Соёлын өвийг хамгаалах тухай 4. Номын сангийн тухай 5. Музейн тухай 6. Киноны тухай 7. Монгол хэлний тухай 8. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 10. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай 11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 12. Садар самуун явдалтай тэмцэх тухай 13. Боловсролын тухай хуулиуд
үүнээс	Нийтлэг мөрддөг хуулийн тоо: 18	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Засгийн газрын тухай 2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай 3. Зөрчлийн тухай 4. Төсвийн тухай 5. Нягтлан бодох бүртгэлийн тухай 6. Шилэн дансны тухай 7. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 9. Төрийн албаны тухай 10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 11. Төрийн хяналт шалгалтын тухай 12. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 13. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 14. Олон улсын гэрээний тухай 15. Инновацийн тухай 16. Патентийн тухай 17. Оюуны өмчийн тухай 18. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиуд
Ерөнхий чиг үүрэг-1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн чиг хандлагыг	1/ Аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийн бодлого, стратегийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн	

тодорхойлох	бодлоготой уялдуулан боловсруулах, төлөвлөх	Аймаг, сумын Засаг дарга, Соёл, урлагийн газар, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	2/ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх орон нутгийн бодлогыг боловсруулах, төлөвлөх	
	3/ Нутгийн иргэд болон түүх, соёлын дурсгалд түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх	
ҮЧҮ-2: Нэгдсэн удирдамжаар хангах	4/ Салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг нэгдсэн удирдамжаар хангах	СУГ
	5/Төсөвт соёл, урлагийн байгууллагуудын ажлыг эрчимжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	
Ерөнхий чиг үүрэг-2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх		
ҮЧҮ-3: Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих	6/ Эх хэл, бичиг үсэг, түүх соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил олгох олон талт арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах	Аймаг, сумын Засаг дарга, Соёл, урлагийн газар, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	7/ Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн онцлогийг харуулсан уламжлалт өв соёлыг хөгжүүлэх	
	8/ Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хамгаалалт, өвлүүлэх, судалж сурталчлах, өвлөн тээгч авьяастныг судлан тодорхойлох, хойч үед уламжлуулах ажлыг зохион байгуулах	
	9/ Аймаг, бүсийн чанартай өв соёлын наадам, арга хэмжээ зохион байгуулах, Улс, бүсийн чанартай наадам, арга хэмжээнд оролцох өвлөн уламжлагчдад дэмжлэг үзүүлэх	
	10/ Соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа, тэдгээрт мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх	
	11/ Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	
	12/Соёл судлалыг хөхүүлэн дэмжих	

	13/Соёлын боловсрол олгох орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	
	14/Орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл, брэнд бий болгох баяжуулах, хөгжүүлэх, сурталчлах	
Ерөнхий чиг үүрэг-3: Үндэсний өв соёлыг хамгаалах, сэргээн өвлүүлэх		
ҮЧҮ-4: Соёлын өвийн менежментийн үндэсний тогтолцоо бүрдүүлэх	15/ Хүн амд соёлын өвийн боловсрол олгох, сурталчлан таниулах	Аймаг, сумын Засаг дарга, Соёл, урлагийн газар, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	16/ Соёлын биет бус өвд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	
	17/ Ойрадын түүх, соёлын өвийг олон улсад сурталчлан таниулах	
	18/Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус хайгуул, малтлагаас урьдчилан сэргийлэх	
	19/Устгах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг хамгаалах, сэргээх, засварлах, сэргээн уламжлах	
Ерөнхий чиг үүрэг-4: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх		
ҮЧҮ-5: Соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	20/ Аймгийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Аймаг, сумын Засаг дарга, Соёл, урлагийн газар, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	21/Соёлын өвд суурилсан соёлын инновац, үндэсний брэндийг бий болгох	
	22/ Бүтээлч үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, бизнес эрхлэлтийг дэмжих	
Ерөнхий чиг үүрэг-5: Соёл, урлагийн ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх		
ҮЧҮ-6: Ойрадын өв соёлыг олон улсад сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх	23/ Ойрадын түүх, соёл, өв уламжлал, ардын урлагийг сурталчлах	Аймаг, сумын Засаг дарга, Соёл, урлагийн газар, төрийн болон ТББ, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, эрдэмтэн, судлаач, иргэд
	24/ Соёлын олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох	
	25/ Олон улсын чанартай наадам, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хуралд оролцох, зохион байгуулах	
Ерөнхий чиг үүрэг-6: Соёлын салбарын хөгжлийн бодлого, хууль, эрх зүй, үйл ажиллагааны тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ		
ҮЧҮ-7: Бодлогын хэрэгжилтийг зохицуулах	26/ Соёл, урлагийн байгууллагын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах	СУГ, харьяа байгууллагууд
ҮЧҮ-8: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	27/Соёл, урлагийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	СУГ

	28/Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох сургалт, сурталчилгаа хийх	
ҮЧҮ-9: Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	29/ Соёл, урлагийн байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, төлөвлөх	СУГ
Ерөнхий чиг үүрэг-7: Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, хүний нөөц, санхүү, технологийг үр ашигтай удирдах		
ҮЧҮ-10: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх	30/ Соёлын сайд, Аймгийн Засаг дарга хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, тайлагнах	СУГ, харьяа байгууллагууд
	31/ Салбарын болон салбар дундын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	
	32/ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах	
ҮЧҮ-11: Хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдах	33/ Соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийг үр ашигтай удирдах	СУГ
	34/ Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	
	35/ Шаардлагатай бусад нөөцийн судалгаа гаргах, нөөцийг үр ашигтай зарцуулах	

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Үндэсний өв соёлоо дээдэлсэн, соёлын үйлдвэрлэл хөгжлийн хувьд тэргүүлэх аймаг болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлж, хэл, түүх, соёлоороо бахархан, эх орноо хайрлах үзэл, ухамсрыг төлөвшүүлэн түгээж, угсаатны соёлын үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Увс аймгийн соёл, урлагийн салбарын хөгжлийн тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, SWOT шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Нөхцөл байдлын шинжилгээ:

Аймгийн хэмжээнд Соёл, урлагийн 22 байгууллагад 232 соёл, урлагийн ажилтан ажиллаж, 4926 үзэгчдийн суудалтай байр танхимаар жилд 2000 гаруй үзвэр, үйлчилгээнд давхцсан тоогоор 300,0 мянга гаруй иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг үзүүлж байна. Мэргэжлийн ажлын хангалт: 2009 онд 29 хувь, 2010-2018 онд 63 хувь, 2019-2021 онд 67 хувь болж өссөн.

Музей болон 16 сумын Орон нутаг судлах танхимаар жилд 9000 гаруй иргэд, гадаад, дотоодын жуулчдад соёлын үйлчилгээ үзүүлдэг. Нийт 17 байгууллагад 9155 үзмэр хадгалагдаж байгаа ба сүүлийн 5 жилийн хугацаанд хандив, төсөл хөтөлбөр, бэлэглэлийн журмаар 239 үзмэрээр баяжилт хийсэн байна.

Жилд 20 номын сангаар 8000 гаруй байнгын уншигч, давхардсан тоогоор 50000 гаруй ирэгсэд үйлчилгээ авдаг ба нийт хүн амын 9.6 хувь хамрагдаж байна. 271367 номын фондтой, сүүлийн 5 жилд улс, орон нутгийн төсөв, төсөл, хандив тусламжаар 167,4 сая төгрөгийн үнэ бүхий 14819 номоор баяжилт хийгдсэн.

Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Ойрад ХЖТ-ын урын санд 70 гаруй уран бүтээл хадгалагдаж байгаа ба 2013-2015 онд ССАЖЯ, Орон нутаг хөгжүүлэх сангаас 220 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, үндэсний өв соёлыг харуулсан "Ээрэн хүрээ", "Шарс отгийнхон хаана байна", "Гурван чимэгтэй наадам" 3 бүрэн хэмжээний уран бүтээлээр баяжилт хийсэн. Эдгээр уран бүтээл нь үндэсний өв соёлыг сурталчлахад чухал нөлөө үзүүлж байна.

Аймгийн хэмжээнд 465 дэсийн 2078 үл хөдлөх дурсгалтай. Улсын хамгаалалтад 6, аймгийн хамгаалалтад 8, сумын хамгаалалтад 2062 дурсгалыг /аймгийн ИТХ-ын 2020 оны 04 сарын 30-ны өдрийн А/46 тоот тогтоол/ бүрэн хамгаалалтад авсан. Нийт дурсгалын 52 хувь буюу 1081 дурсгалыг сумын Засаг дарга, Соёлын төвийн эрхлэгч, иргэн 3-сан гэрээ байгуулж хариуцуулсан.

Соёлын биет бус өвийн 430 гаруй өвлөн уламжлагчтай. 2010-2018 онд бүс, аймгийн чанартай 8 удаагийн язгуур урлагийн наадам, хүүхдийн авьяас уралдаан зохион байгуулж, 1284 ардын авьяастан, 5000 гаруй хүүхэд

хамруулсан. Ази, олон улс, бүсийн чанартай 14 удаагийн уралдаан наадамд 354 авьяастныг дэмжиж оролцуулж, соёлын биет бус өвийг залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор 6 удаагийн төслийн сургалт зохион байгуулж, 567 хүүхэд хамруулсан.

Соёлын үйлдвэрлэл эрхэлдэг 60 гаруй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, компанид 900 гаруй хүн ажиллаж байна /2005 оны Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай конвенцын хэрэгжүүлтийн тайлангийн хүрээнд хийгдсэн судалгаа/. Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор ЖДҮ хөгжүүлэх сангаас 2013-2019 онд аялал жуулчлал, ноос, сүү сүүн бүтээгдэхүүн, модон эдлэл, сийлбэрийн урлал, баяд цагаан улт гутал үйлдвэрлэл, чацаргана тариалалт зэрэг 52 төсөлд 1,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, ажлын байр нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

Дотоод орчны шинжилгээ:

Орон нутгийн Соёл, урлагийн газрын чиг үүргийн хувьд:

- Үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх
- Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах
- Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
- Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

Гадаад орчны шинжилгээ:

Улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг тооцоолсон.

Увс аймгийн Соёл, урлагийн газрын SWOT шинжилгээний үр дүн

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Бие даасан яамтай болж, орон нутагт Соёл, урлагийн газар байгуулагдсан • Үндэсний өв соёл, зан заншлаа дээдэлсэн ард түмэн • Соёлын үйлдвэрлэл, инноваци хөгжих боломж бүрдсэн • Байгалийн үзэсгэлэнт газар олон, аялал жуулчлалын нөөц сайтай • Нийслэл Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон 	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн боловсон хүчний нөөц дутмаг, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого байхгүй • Соёлын салбарт шинэчлэл хийх, багшийг чадавхжуулах шаардлагатай • Ажил үүргийн хуваарь оновчтой бус, ажлын уялдаа холбоо хангагдаагүй • Соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн цалин, урамшуулал бага • Соёлын ажилтан, уран бүтээлчдийн мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх тогтолцоо сул

<ul style="list-style-type: none"> • ОХУ-тай хилийн гарцтай 	<ul style="list-style-type: none"> • Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, хадгалж, хамгаалах арга технологи дутмаг • Соёлын өвийг баримтжуулахад шаардагдах мэргэжлийн тоног төхөөрөмжийн хангалт муу • Үйл ажиллагаа явуулах төсөв хүрэлцээгүй
ГАДААД ОРЧИН	
Боломж	ЭРСДЭЛ
<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас соёлын салбарт онцгой анхаарч байна • Орон нутагт бие даасан Соёл, урлагийн газар байгуулагдсан • Соёлын тухай <i>/шинэчилсэн найруулга/</i> хууль хэрэгжсэнээр албан хаагчдын нийгмийн асуудал, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж байна • Соёл, урлагийн байгууллагууд өөрийн орлогоо захиран зарцуулах эрхтэй болсон • Соёл, урлагийн салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байна • Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр, аймгийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт Ойрадын өв соёлыг хөгжүүлэх талаар тусгагдаж, хэрэгжиж байгаа • Соёлын өвд суурилсан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой • Дотоод, гадаадын аялагчдыг татах 	<ul style="list-style-type: none"> • Алслагдмал байдал • Хүний нөөцийн чадавхи дутагдалтай • Ковид-19 цар тахлын нөлөөллөөс соёл, урлагийн арга хэмжээ зогсонги байдалд орж, орлогын хэмжээ буурсан • Цахимжилт бүрэн хийгдээгүй • Нарийн мэргэжлийн сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах үйл ажиллагаа дутмаг • Бүх нийтийн соёлын боловсролын түвшин доогуур • Оюуны өмчийг үнэлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бүрдээгүй • Техник, тоног төхөөрөмж хоцрогдсон • Соёлын биет болон биет бус өвийн хамгаалалт сул, дэмжлэг байхгүй

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Үндэсний өв соёл, түүх, урлагийн үнэ цэнийг улс, бүс нутгийн хэмжээнд өсгөх, хүн амыг соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Энэхүү стратегийн зорилгын хүрэх үр дүнг дараах зорилтуудаар хэрэгжүүлэхээр тодорхойллоо. Үүнд:

Стратегийн зорилт-1. Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт-2. Соёлын салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт-3. Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээ зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт-4. Соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлнэ

Стратегийн зорилт-5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт-6. Стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Стратегийн зорилт-7. Үндэсний болон орчин үеийн урлагийг хослуулан хөгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ.

----oOo----

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
2 дугаар хавсралт

Төлөвлөгөөг баталсан: *Төсвийн Ерөнхийлөн захирагч*
Соёл, урлагийн газрын дарга *.....* /А.Баярмагнай/
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)
Тэмдэг *.....*

Төлөвлөгөө боловсруулсан: *Соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн*
Ахлах мэргэжилтэн *.....* /Т.Оюунцэцэг/
(албан тушаал) (гарын үсэг) (огноо)
Тэмдэг *.....*

УВС АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ (2021-2024 он)

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр-1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах					
Ерөнхий чиг үүргийн нэр-6: Соёлын салбарын хөгжлийн бодлого, хууль, эрх зүй, үйл ажиллагааны тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ					

<p>Үндсэн чиг үүргийн нэр - 1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох</p> <p>Үндсэн чиг үүргийн нэр – 2: Нэгдсэн удирдамжаар хангах</p> <p>Үндсэн чиг үүргийн нэр- 7: Бодлогын хэрэгжилтийг зохицуулах</p> <p>Үндсэн чиг үүргийн нэр-8: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах</p> <p>Үндсэн чиг үүргийн нэр-9: Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p>					
<p>Стратегийн зорилт-1.</p> <p>Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>1/Соёлын байгууллагын удирдлага,зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй,хүртээмтэй,үр ашигтай ,механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай ,шуурхай хүргэнэ</p>	<p>Соёл,урлагийн нэгж байгуулагдсан тоо</p>	-	<p>21 аймагт соёл,урлагийн нэгжийг байгуулан,байрны асуудлыг шийдвэрлэж үйл ажиллагааг тогтворжуулсан байна</p>	<p>Улсын төсөв</p>
	<p>2/Соёл урлагийн байгууллагуудын интернэтийн урсгалыг сайжруулах техник тоног төхөөрөмжөөр хангах, цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Техник тоног төхөөрөмжийн тоо</p>	-	<p>Интернэт болон тоног төхөөрөмжөөр хангагдсан байна</p>	-
	<p>3/Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох сургалт сурталчилгаа хийнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	-	<p>Төсвийн тухай, шилэн дансны тухай, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээний худалдан авах тухай хууль гэх мэт хуулийн талаар сургалт хийсэн байна</p>	-
	<p>4/Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг хөтөлбөр төслийн хэрэгжилтэнд няналт шинжилгээ үнэлгээ хийх үр дүнг тайлагнана.</p>	<p>Баримт бичгийн хэрэгжилтийн хувь</p>	-	<p>Бодлогын баримт бичиг хөтөлбөр төслийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тайлагнасан байна.</p>	<p>Соёл урлагийн газар</p>

Ерөнхий чиг үүргийн нэр-1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах					
Үндсэн чиг үүргийн нэр - 1: Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох					
Зорилт-2. Соёлын салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	5/Соёл урлагийн салбарын боловсон хүчнийг үе шаттай бэлтгэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хөгжүүлэх, мэргэшүүлнэ.	1. 2.	1.60 2.0	1.80 2.20	
Ерөнхий чиг үүргийн нэр-1: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх					
Үндсэн чиг үүрэг – 3 Үндэсний өв соёлыг хамгаалах, сэргээн өвлүүлэх					
Зорилт-3 Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээ зохион байгуулж, соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.	6/“Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Арга хэмжээний тоо	-	Орон нутгийн иргэдэд соёлын боловсролыг олгох арга хэмжээг хөгжүүлсэн байна.	
	7/Номын сангийн үйлчилгээг дижитал хэлбэрт шилжүүлэн иргэдэд хүрэх үйлчилгээний төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Цахим сан хөмрөгийн эзлэх хувь, үйлчилгээний тоо	-	Дижитал хэлбэрт шилжүүлэх шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангаж, үйлчилгээний төрөл нэмэгдүүлсэн байна.	
	8/Соёлын төв, номын сангийн үйл ажиллагаанд тавигдах стандарт шаардлагыг хангаж ажиллана.	Шаардлаг хангасан номын сан , соёлын төвийн тоо	-	Стандартын шаардлага хангасан номын сан , соёлын төвтэй болсон байна.	
Ерөнхий чиг үүрэг-3: Үндэсний өв соёлыг хамгаалах, сэргээн өвлүүлэх					
Үндсэн чиг үүрэг.-4: Соёлын өвийн менежментийн үндэсний тогтолцоо бүрдүүлэх тодорхойлох					
	9/Хууль сахиулах байгууллага болон хяналтын байгууллагатай хамтран соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		Соёлын өвийн гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх талаар сургалт зохион байгуулсан байна.	

Зорилт-4 Соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлнэ	зөрчилтэй тэмцэх талаар хамтран сургалт зохион байгуулна.		-			
	10/Хүн амд соёлын өвийн боловсрол олгож, иргэд сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна.	Бүртгэгдсэн баримтат өвийн тоо	2021 4 ,84 639	50		Орон нутгийн төсөв
	11, -		- 15			Улсын болон орон нутгийн төсөв
Ерөнхий чиг үүрэг-1 Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, нэгдсэн удирдамжаар хангах						
Ерөнхий чиг үүрэг - 4 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх						
Үндсэн чиг үүрэг - 1 Орон нутгийн соёлын салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох талаар баримтлах						
Үндсэн чиг үүрэг -5 Соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх						
Зорилт-5 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.	12/ Орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл, брэнд бий болгох баяжуулах, хөгжүүлэх, сурталчлах		-	5-		
	13/ Нутгийн иргэд болон түүх, соёлын дурсгалд түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх		-	<i>Дотоод гадаадын аялагчдад соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнээр үйлчилсэн байна</i>	

		бодлогыг боловсруулах			
Ерөнхий чиг үүрэг- 2 Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх					
Үндсэн чиг үүрэг – 6 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх					
Зорилт-6 Стандарт, шаардлагад нийцсэн соёлын барилга байгууламжийг ашиглалтад оруулж, соёл, урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	14/ Соёл урлагийн газрын барилга байгууламж шинээр барьж ашиглалтанд оруулах	Соёл урлагийн газрын барилга угсралтын ажлын хувь	Зураг төсөл байхгүй	Барилгыг бүрэн ашиглалтанд оруулсан байна.	
	15/ Музейн барилга шинээр барьж ашиглалтанд оруулах	Музейн барилга угсралтын ажлын хувь	Зураг төсөл байхгүй	Барилгыг бүрэн ашиглалтанд оруулсан байна.	
	16/ Төв номын сангийн барилгыг шинэчлэн засварлана.	Их засварын ажлын гүйцэтгэлийн хувь	-	Их засварын ажил хийгдсэн байна.	
	17/ Малчин, Бөхмөрөн, Сагил, Өмнөговь сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих	Соёлын төвийн барилга угсралтын ажлын хувь	-	Соёлын төвийг шинээр ашиглалтанд оруулсан байна.	
	18/ Түүхэн дурсгалт Харлаг бэйсийн сүмийн барилгын сэргээн засварлалт хийх	Сэргээн засварлалтын гүйцэтгэлийн хувь	-	Сэргээн засварлалтыг бүрэн гүйцэтгэж оруулсан байна. ашиглалтанд	
Ерөнхий чиг үүрэг-2: Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх					
Ерөнхий чиг үүрэг-5: Соёл, урлагийн ололт амжилтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх					
Үндсэн чиг үүрэг -3 Соёл, урлагийг хөгжүүлэх, дэмжих баримтлах					
Үндсэн чиг үүрэг -6 Ойрадын өв соёлыг олон улсад сурталчлан таниулах, нөлөөллийг нэмэгдүүлэх тодорхойлох					
	19/ “Сонгодог урлаг III” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	“Сонгодог урлаг II” үндэсний	“Сонгодог урлаг III” арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	

Зорилт-7 Үндэсний болон орчин үеийн урлагийг хослуулан хөгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ.	20/		хөтөлбөр хэрэгжиж дууссан		
	21/ Олон улсын чанартай наадам, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хуралд оролцох, зохион байгуулах				